

ӨНДӨР ТЭРЭГТЭН АЙМГУУДЫН ТҮҮХИЙН АСУУДАЛД

Б.БАТСҮРЭН

Товч агуулга: Монгол орон түүнтэй залгаа бүс нутаг бол монгол, энэтхэг-европ, түрэг хэлтэн эртний нүүдэлчин аймгуудын өлгий нутаг юм. Гэхдээ эртний жинхэнэ түрэг хэлтэн аймгууд болох өндөр тэрэгтнүүд III зууны хоёрдугаар хагаст Монголын Хангайн бүс нутагт нүүж иржээ. Тэд Хүннүгийн үед түүний баруун гарт багтаж Зүүн гар, Алтай бүс нутгаар сууж байв. Чухам энэ түүхэн үйл явдлыг сэргээн толилуулах зорилгыг тус өгүүлэл агуулж байгаа юм.

Түлхүүр үг: Уйгур, Хүннү, домог, Алтай, Зүүнгар, нүүдэл

Өндөр тэрэгтний гол аймгийн нэг *уйгуруудын* нугсаа гарвалын домог, түүхүүд “Вэй улсын судар”, “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”, “Судрын чуулган”, “Юань улсын судар” гэсэн эртний хятад, перс хэлний сурвалжид хадгалагдан үлдсэн байдаг.

Хархорум хотод сууж байхдаа эхлэн зохиож, хожим Хулагу (Үлэгү) хааны дэргэд очоод 1260 онд бичиж төгсгөсөн¹ “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх зохиолдоо Ата-Малик Жувейни (1226-1283) Уйгурын түүхийг тэдний судар номоос түүж бичсэн гэж дурджээ. Домогт, Хархорум уулаас эх авдаг, Орхон голын хөвөөнд тэдний уг язгуур үүсч өсч үржсэн гэж *уйгурууд* өгүүлжээ. Хархорум уулаас гучин гол эх авч урсдаг, гол болгонд тусгаар ард түмэн нутаглана. Орхоны *уйгурууд* хоёр салбар болж байв. Тэдний тоо олширсонд тэд бусад ард түмний жишгээр өөрсдийн дундаас ахлагч сонгон түүнд захирагдав. Тийм байдлаар **Буку ханыг хүртэл таван зуун оныг үджээ**. Бас тэд Буку хан бол Афрасиаб юм гэж хэлэлцдэг. Хархорум уулаас холгүй орших нэгэн толгой дээр худгийн үлдэгдэл, бас асар том чулуу байдаг ба түүнийг Бизаны гяндан хэмээн ярьцгаадаг. Мөн голын эрэгт, өнөө цагт Маубалык (Муу балгас) гэж нэрлэдэг болсон ч эрт цагт Ордубалык (Орд балиг) гэдэг байсан хот, орд харшийн турийг үзэж болно. Ордноос холгүй хаалганы эсрэг талд нэлд нь үсэг бичиг сийлсэн чулуунууд хэвтэж байдгийг бид өөрсдийн нүдээр харсан билээ. Хааныг (Өгэдэй) төр барьж байх үед эдгээр

¹ *БНМАУ-ын түүх*. Тэргүүн боть. Улаанбаатар: 1966, 28

чулууг өргөж босгоход доороос нь бас нэг худаг олсон. Худагт бичиг сийлсэн том дөрвөлжин хавтгай чулуу байв. Тэгэхэд тэр бичгийг тайлан уншиж чадах хэн ч байсан өөрсдөө ирж нэр усаа танилцуул гэсэн зарлиг гаргасан боловч хэн ч уншиж эс чадав. Тиймээс, Китай (Хятад) орноос^{1*} <...> хэмээгдэх хэдэн хүнийг урьж авчирсан бөгөөд тэр чулуун дээр цохон сийлсэн бичиг, тэд нарын бичиг үсэг байв. (Чулуунд ингэж сийлжээ:)

Тэр цагт Хархорумын хоёр гол, нэгийг Туул, нөгөөг нь Сэлэнга гэж нэрлэдэг [хоёр гол] нийлээд хамтдаа Камланчу нутгаар урсдаг; тэрхүү хоёр голын дунд бие биетэйгээ маш ойрхон хоёр мод ургажээ; тэдний нэг нь хэлбэр дүрсээрээ нарстай адил, *кушук* (хуш) гэдэг, түүний орой өвөл цагт яг агар модны орой шиг харин түүний үр нь хэлбэр, амтаараа хуш модны боргоцойг санагдуулдаг; нөгөөг *тоз* (хус) гэнэ. Хоёр модны хооронд асар том дов ургасан бөгөөд түүн дээр тэнгэрээс гэрэл буух тул өдөр ирэх тусам томорсоор л байв. Энэхүү үзэгдлийг харсан *уйгур* аймгууд ихэд гайхан; хүндэтгэлтэйгээр бас хүлцэнгүйгээр дов руу дөхөөд дуутай төстэй аятайхан, тааламжтай чимээ сонсов. Тэгээд шөнө болгон энэ гэрэл эргэн тойрондоо гучин алхмыг гэрэлтүүлэх ба хээлтэй эм тулгар болохын адил тэнд хаалга нээгдгэл хойно нь нялх хөвүүд суух, гэр лүгээ төстэй таван тусгаар үүр байлаа; хөвүүдийг угжсан ба харин гэр дээр нь мөнгөлсөн тор татав. Аймгийн ахлагчид энэхүү гайхамшгийг үзэхээр ирээд үнэнчийн бэлгэдэл болгон өвдөг нугалан ёслол. Хөвүүдэд сэвэлзүүр салхин хүрэхүй тэдэнд хүч чадал нэмэгдэж тэд хөдөлцгөөв. Эцэст нь тэднийг гэрээс гарахад өрлөг ижий нарт өгч харин хүмүүс тэднийг хүндлэн үйлчлэх болов. Хөхөхөө болимогц ярьж сурсан тэд эцэг эх нь хэн болохыг асуухад хүмүүс мөнөөх хоёр модыг зааж өгөв. Хөвүүд тэдгээр мод руу хүрэлцэн очоод сайн хөвгүүд эцэг эхдээ үзүүлдэг тахимдал лугаа адил мэхийн ёсолжээ; тэд бас модод ургасан газарт бишрэл, хүндлэлийг илэрхийлэв. Тэгтэл модод [өөр зуураа] хэлэлцээд ийн өгүүллүүн: “Буянт эрхэм чанарыг хүртсэн, сайн хүүхдүүд минь ямагт энэ жимийг даган ирж эцэг эхийнхээ өмнө өөрсдийн үүргээ байнга биелүүлж яв! Амьдрал тань урт байж алдар тань мөнхөд хадгалагд!” гэлээ. Энэ хязгаар нутгийн бүхий л аймгийнхан хөвүүдийг харахаар хүрэлцэн ирж тэдгээр ханхүүдэд ёслол лугаа адил хүндэтгэв; харих зуураа тэд тэдгээр хөвгүүдэд тус бүрт нь нэр хайрлав; ууганыг нь тэд Шонкур тегин гэж удаахыг нь Котур тегин гэж гутгаарыг нь Түкэл тегин гэж дөрөв дэх хүүг Ор тегин гэж харин тав дахийг

¹ Энэ хэсэг тус сурвалжийн С хувилбараас бусад нь байдаггүй, QAMAAN гэдгийг qams буюу бөө гэж унших нь эргэлзээтэй (Boyle, J.A. “The History of the World-Conqueror”. Vol. I. *HUP.*, 1958, 55 n. 10).

нь Буку тегин хэмээв. Хачин жигтэй эл хэргийг тунгаан шүүгээд хүмүүс, нэгэнт л тэдгээр хөвүүдийг бүхнийг чадагч бурхан тэнгэр илгээснээс хойш, хөвүүдийн нэгийг өөрсдийн удирдагч, хаан болгох хэрэгтэй гэж шийджээ. Тэд, Буку хан бусдаасаа цэвэр царай зүстэй, өөрийн оюун чадал, эргэцүүлэн бодох нь илүү болохыг мэджээ; үүнээс гадна тэр бусад бүх улс түмний хэл, бичигт нэвтэрсэн нэгэн болжээ. Тиймээс бүгд, түүнийг хаан болгоход сэтгэл нэгтэй байж тэгээд тэд хуран цугларч хөгжилдэн наадсаны хойно түүнийг хан сууринд залсан гэж өгүүлдэг.

Жувейнийн зохиолд уг түүхийг цааш үргэлжлүүлэхдээ Буку хан сууринд заларч улс орноо удирдаж, хөрш Монгол, Киргиз, Тангут, Түвэд, Хятадыг хэрхэн довтолсон, Баласагун хотыг байгуулсан зэрэг үйл явдлуудыг дурдаад Буку хан үхсэний дараа үр хүүхэд нь уламжлан улс орноо захирах болсон тухай дурддаг.

Уйгурын уг гарвалыг өгүүлсэн энэ домгийг тэр цагийн олон бичгийн мэргэд мэддэг байжээ. Рашид ад-дин (1247-1318)-ий 1311 онд бичиж дуусгасан “Судрын чуулган”-д “Бүгү хан, эрт цагт их газар орныг эзэлсэн хүчирхэг хаан байж, *уйгур* болон бусад олон аймагт их хүндлэгдэж чухалчлагдаж байв. Тэд түүнийг модноос төрсөн гэж хэлэлцдэг” гэж тэмдэглэсэн бол Марко Поло энэ домгийг мэддэг байжээ. Юань улсын сударт тэмдэглэсэн нэг хувилбар нь Жувейнийн тэмдэглэсэнтэй гайхалтай адил байдаг.

Домогт гардаг Буку ханыг түүхэн бодит хүн байсан гэж эрдэмтэд нотолсон. “Жувейний өгүүлсэн нь уйгурынх болох нь” гэсэн 1912 оны өгүүлэлдээ Ж.Маркварт, Буку бол түүхэн бодит хүн, Харбалгасын руни бичээст гардаг хаан гэж үзсэн бол П.Пеллио, Жувейнийн хэрэглэсэн Буку нэр бол Уйгурын домогт гардаг Бүгү гэсэн анхны хааны нэрийн нэг хувилбар мөн гэж В.В.Бартольддын “Туркестан” зохиолын шүүмждээ хэлжээ.¹

Уйгурын түүхэнд Бөгү нэртэй, улсаа 759 оноос эхлэн 20 жил захирсан хаан үнэхээр бий. Мөн 860-аад онд Монгол орноос *токуз огузуудыг* хотлоор нь дагуулж нүүгээд Дорнод Туркестанд очиж, шинэ улс байгуулсан Букут (Пугу) аймгийн язгууртныг Буку Чин гэж бас нэрлэдэг.

Тус домгийн Орхон, Туул, Сэлэнгэ, Хархорум гэсэн газар усны нэрийг өдгөө хүртэл хэрэглэж байгаа явдал домгийн зарим үйл явдал бодит түүх мөнийг зааж байгаа сонирхолтой баримт болно. Тиймээс Буку ханыг бодит хүн гэж үзэх үндэслэл улам нэмэгдэж байна.

¹ Boyle, J.A. “The History of the World-Conqueror”. Vol. I. HUP., 1958, 53-57; Джувейни. *История завоевателя мира*. Перевод с англ. Е.Е.Харитоновой. Москва: 2004, 36-37, 548, 549

Рашид ад-диний зохиолын Уйгурын түүх (аман түүх) илүү нарийн тодорхой мэдээлэлтэй. “Уйгур” нэрийг хэрхэн авсаныг дурдаж домог эхэлдэг. Түүнд, Огуз хаан *уйгуруудтай* зөвшилцсөний эцэст Уйгур нэрийг хайрласан. Түрэг хэлэнд “нэгдээд тусламж үзүүлэх” гэсэн утгатай. Тэгээд нэр авсан бүлэг иргэнд, улмаар тэдний удмын салаа салбар, овгуудад түгэн тархсан гэж өгүүлжээ. Уйгур улсад үлэмж том хоёр уул бий нэгийг нь Букрату Бузлук, нөгөөг нь Ишкунлук Тэнгрим/Ушкун-Лук Тэнгрим^{1**} гэдэг; энэ хоёр уулын дунд Хархорум уул оршдог. Тэр хоёр уулын дараа Кут-таг гэх өөр уул байдаг. Тэдгээр уулсын хажууд нэг газар арав, нөгөөд нь есөн гол бий. Эрт цагт уйгур аймаг эдгээр гол, уулс хөндийгөөр нутаглаж байв. Арван голд нутаглагчдыг Он-уйгур, есөн голд нутаглагчдыг Токуз-уйгур гэнэ. Арван голыг Он Орхон гэдэг. Ишхөл/Ишлик, Өтигэр/Утингэр, Тохир/Бурыз, Орхундур/Узкундур, Тулу/Тулар, Бадар/Тардар, Адар, Уч Табин, Камланжу болно. Эхний 3 голоор 9 аймаг, гэсэн удаах 4 голоор 5 аймаг нутаглана. Камланчу гэдэг газар есдэх аймаг Онг/Лун түмэн нутагладаг. Өтигэнээр нутаглагч аравдахь аймгийг Кахан Ати/Кумык-Атыкуз гэнэ. Голоор нутаглагч эдгээр аймгийн хажууд нэр үл мэдэгдэх 122 овог, аймаг² хөршилж суудаг гэжээ. Он жилүүд өнгөрсөөр байсан ч хаад толгойлогчгүй байсаар бав. Аймаг бүрт хэн нэгэн дуртай үедээ ахлагчийн суудлыг хүчээр булааж байв. Ахлагчгүй хэдэн үе өнгөрсний хойно бүгд зөвлөлдөөд Эбишлик (Ишхөл) аймгаас Мэнгүтай гэдэг хүнд “эльтебер/ил-илтибир” цол өгч, Узкундур (Орхундур) аймгаас нэгэн хүнийг сонгон “күл эрхин/кул-иркин” цол өгч хоёуланг аймгийн толгойд тохоон талбижээ. Тэдний ураг зуугаад жил хаанчилсан³ гэж Рашид ад-дин Уйгурын түүх домгоо төгсгөдөг.

Жувейни, Рашид ад-дин нарын тэмдэглэсэн Уйгурын түүх, домгийн нэг хувилбарыг “Юань улсын судар”-т тэмдэглэжээ. Түүнд, Холин (和林, Хэлинь) уулаас хоёр ус гаржухуй. Тухула (秃忽刺, Туул) хэмээмой. Сюэлинхэ/Селингэ (薛靈哥, Сэлэнгэ) хэмээмой. Эрт цагт *уйгурууд* нутагладаг байсан гэж дурдаад

¹ Букрату Бузлукуыг “буур” (bughra) эсвэл “мөсөөр хучигдсан” эсвэл “хүйтэн” гэж тайлбарладаг. Ишкуныг “гишүүнэ” гэжээ. “Гишүүнт Тэнгэр уул” гэсэн үг бололтой.

² 122 аймаг лав биш байх, овог буюу було болов уу гэж таамаглаж байна. М.э. II зууны эхэн үеийн Сяньбид 120 було байсан билээ. Энэ жишгийг дагавал энэхүү 122 нь тус бүртээ 2-3 мянгаад хүнтэй було/бүлэг болно. Нийтдээ 305-360-аад мянган хүнтэй нүүдэлчид гэсэн үг. Бид өмнө хэвлэгдсэн нэгэн өгүүлэлдээ 692-720 иод оны үеийн Түрэгийн хаант улсад токуз огузын ес орчим аймаг 272 мянган хүнтэй байсан гэж сурвалжийн мэдээг үндэслэж тооцоолсон билээ. Ер нь Түрэгийн хожуу хаант улсад 300-400 мянгаад хүн амьдарч байсан гэж тэнд үзсэн. (Батсүрэн, Б. “Гучин Түрэг (otuz türk\otuz türk)-ийн асуудалд”. - *Эртний Түрэгийн түүх, соёл*. Эрхэлсэн Ц.Баттулга. 2015, 95-96) Багцаагаар ойролцоо тоонууд байгаа нь 122 аймаг бус овог байжээ гэсэн таамгийг бататгаж байна.

³ Рашид ад-дин. *Сборник летописей*. Том I, книга 1. М.-Л., 1952, 147; Rashiduddin. Jami' u't-tawarikh: Compendium of Chronicles. Vol. I, pt. I. HU., 1998, 75

анхны хаад хэрхэн төрсөн домгийг өгүүлээд Бука хаан (不古可罕, Бүгү кэхань) эзэн дарга болсноос хойш гуч илүү эзэн уламжилсан. Тангийн үед Юйлуны тигин (玉倫的斤) байсан Тан улс лугаа харилцан байлдаж байсан, удаан хэлэлцсэний эцэст дайн байлдааныг зогсоохыг тулд Тан улс Юйлуны тегиний хүү Гэли (葛勵) тегинд Цзиньлянь гүнж (金蓮公主)-ээ өгсөн гэж дурддаг. Уйгурын хүчийг сулруулах арга олсон Тангийн хүмүүс Хэлинь (Голинъ) нутгийн нэг уулын чулууг авч явсанаар Юйлуны тегин үхэж хүмүүс нь нутгаасаа нүүж Цзяочжоу¹ (交州) хүрч тэр хавийн нутгийг эзэлж суух болсон гэж дурджээ. Улмаар “**970 илүү жил болоод Барчук тегин** (Баэлжуаэлтэ тигин/Баэрчжуарэтуй дэцинь, 巴而朮阿而忒的斤) хүрч ирэн Хитан улсад түшмэл болжухуй. Шаргачин могой жил (1209) Тайзу (Чингис хаан)-гийн умард газар мандсаныг сонсч даруй Хитан улсын ... түшмэлийг алаад дагаар ирсэн” гэж тэмдэглэжээ.²

XIII-XIV зууны үеийн 3 сурвалжид тэмдэглэсэн Уйгурын түүх бол тэдний үеэс үед дамжуулж ирсэн аман түүх. Харин эдгээр түүхээс арай эрт цагт тэмдэглэгдэн үлдсэн нэг домог эртний хятад сурвалжид байдаг.

Монгол хэлтэн *табгач* нарын түүхийн эмхтгэл “Вэй улсын судар”-т Уйгурын ноёлох овгийн ялангуяа тухайн ургийн дээд эмэг эхийн талаарх нэг домгийг тэмдэглэжээ. Домогт ийн өгүүлдэг: олон түмэн, Хүннүгийн шаньюйд хосгүй үзэсгэлэнт хоёр охин төрсөн гэж хэлэлцдэг бөгөөд тиймээс тэдгээрийг бурхад гэгцгээн ард олон шүтэх болов. Шаньюй зарлигдсан нь “Надад хэдүй ийм охид заяасан ч би тэднийг хүн төрөлтөнд өгч болно гэж үү? Би тэднийг тэнгэрт өгөх болно гэв”. Үүний дараа нутгийнхаа хойд хэсэгт нэгэн хүн амьтангүй газарт өндөр дэвсэг овоолон босгож хоёр охиноо суулгаад хэлсэн нь “Тэнгэр тэднийг таалах болтугай” гэв. Гурван жил өнгөрөөд эх нь охидоо эргэх гэсэн ч шаньюй “болохгүй, тэднийг шилжилт хүлээж байгаа” гэжээ. Дахин нэг он өнгөрч байтал нэгэн хөгшин чоно үзэгдэх болж улмаар өдөр шөнөгүй довцгийг хамгаалангаа нүх малтах болов. Тэр чоно довцгийн ёроолд нүх малтан ороод түүнээс ер цухуйхгүй байжээ. Тэр үед дүү нь хэлсэн нь “Бидний эцэг энд намайг тэнгэрт таалуулахын тулд суулгасан. Одоо чоно ирсэн нь магадгүй тэнгэрийн илгээсэн бэлгэ биз” хэмээгээд довцогоос бууж чоно руу очихыг хүссэнд эгч нь ихэд эмээн багтарч өгүүлсэн нь “Энэ бол араатан, чи эцэг эхийн нэрийг гутаахаас өөр зүйл олохгүй” гэв. Дүү нь түүнийг үгийг үл тоон довцогоос доош буун чонын эхнэр болоод хүү

¹ В.В.Радлов зохиолдоо Хочжоу гэж бичсэн, Уйгурын нийслэл Харахожо болно. Турфанаас зүүн өмнө 30 км-т байсан.

² 元史。卷122。第2999-3000頁； Дэмчигдорж. *Юань улсын судар*. СХIV-СХХVII дэвтэр. Улаанбаатар: 2016. т. 295-298; Радлов, В.В. *Къ вопросу объ уйгурахъ*. СПб., 1893, 63-64

төрүүлэв. Хожим нь түүний ураг олшрон улмаар улс иргэнийг олсон бөлгөө. Энэ улсын хүн ард чоно улихтай адил урт үргэлжилсэн дууг дуулах дуртай”¹ болсон гэж өгүүлдэг домгоор бол *уйгурууд* түүний дотор язгууртан ноёлох ураг нь Хүннүгийн хаадын ургаас хатан буулгадаг байсан нь харагдаж байна.

Тиймээс Н.Я.Бичурин тэртээ XIX зуунд Ойхор (Уйгур, Хойху) ургийн уг бол Хүннүгийн эмэгтэй талаас эхтэй гэж хятадын түүх өгүүлдэг: тиймээс, *ойхор* ургийг үндэслэгч нь *дили* (өндөр тэрэгтэн) овог аймгуудын холбоонд хамрагдаж байсан эзэн ноёнд очсон хүннүгийн ханы охины хүү буюу зээ гэдэгт эргэлзэх шаардлага үгүй² гэж дүгнэсэн.

Жувейнийн тэмдэглэсэн Уйгурын угсаа гарвалын домгоор бол *уйгур* нарт хаан суусан Буку ах дүүсийн хамт *кушук*, *тоз* (хуш ба хус) модыг төрсөн эцэг эх хэмээн хүндэтгэл, ёслол үйлдэж байна. *Уйгурууд* мод, хөвч тайгад ургадаг *хуш*, *хус* модыг шүтэж байсныг энэ домог гэрчлэхийн хамт өвөг дээдэс нь хаагуур нутаглаж байсныг зааж байгаа юм. “Вэй улсын судар”-г өгүүлснээр уйгурын дээдэс эрт цагт Хүннүгийн шаньюйн бага охиныг хатан буулгажээ. Хүчирхэг улсын хаадын ургаас хатан буулгах нь ердийн үзэгдэл. Чингэснээр бага овог, аймгууд бусад овог, аймгуудын дунд нэр хүнд, эзлэх байр сууриа өсгөдөг. Нэг жишээ дурдъя. Өмнө нь Усунь, Канцзюй хоёрын дунд оршиж, тэр хоёрын довтолгоонд байнга хэлмэгдэж явсан хүч нэн буурай Ушаньму (烏禪幕, wushanmu) гэгч жижиг аймгийн толгойлогч хэдхэн мянган хүнээ дагуулан Хүннүд дагаар ороход Хулугу шаньюй дүүгийнхээ хүү жичжу вангийн охин дүүг эхнэр болгон өгч баруун хязгаарт захирагч тавьж байв.³ Хүннүгийн хааны удамтай ураглах явдал өөрөө их үр өгөөжтэй улс төрийн үйлдэл. Өөр ч ашигтай талууд бий. Тиймээс тухайн үйл явдлыг олон үеийн турш дурсан хэлэлцэх нь зүй ёсны хэрэг. Нөгөө талаар уйгурын язгууртнуудын нэг гол ураг нь худ ургийн харилцаагаар Хүннүтэй холбогдож байгаа тул түүх сударт *уйгурын* “өвөг дээдэс *хүннү нар*”⁴ гэж тэмдэглэсэн нь нэг талаар зөв. Гэвч энэ нь зөвхөн Уйгурын хаад ихэсийн дээд өвгүүд Хүннүтэй холбоотой байсныг зааж байнаа гэдгийг ямагт хатуу санах хэрэгтэй. Маш товч сурвалжийн эл мэдээ эртний *уйгур* аймгийн хүн ардад огт хамаагүй баримт юм.

¹ Таскин, В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Москва: 1984, 401, 402

² Бичурин, Н.Я. *Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена*. Т. 1. Мүсква: 1950, 213

³ De Groot, J.J.M. *Die Hunnen der Vorchristlichen Zeit*. В-Л., 1921, 204-205

⁴ Сүхбаатар, Г. *Монголын түүхийн дээж бичиг*. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар: 1992, 61

Табгач Вэй улсын (386-534) үед Хятад оронд Хүннүгийн үеийн *динлин* аймгийг Өндөр тэрэгтэн динлин (гаогюй/гаоцзюй динлин, 高車丁零) эсвэл Гаогюй (Гаочэ, Гаоцзюй) гэж нэрлэх болсон хэмээн судар бичгүүдэд өгүүлжээ. Энэхүү Гаогюйгийн 6 их аймгийн нэгийг Юаньгэ (袁紇, EMC. wuan-γ t < уйгур) гэдэг байжээ. Үүнээс үзвэл *уйгурууд* эртнээс Динлин нэр зүүдэг олон овог, аймгийн нэг байсан гэдэг нь тодорхой харагдана. Иймээс судлаачид *уйгуруудын* өвөг дээдэс бол м.э.ө. III зууны үед өмнөд Сибириэр байсан эртний *динлин* аймаг¹ гэж үзсээр, бичсээр ирсэн.

Гагцхүү сурвалжийн мэдээг үндэслэвэл Уйгур нэр түүхэнд бүр Модун шаньюйн үед хамгийн анх гарчээ. Динлинтэй хамт зэрэгцэж тэмдэглэгдсэн байдаг.

М.э.ө. 177 онд Хань улсын хилийг уулгалж хоёр улсын байгуулсан гэрээ хэлэлцээрийг зөрчсөн баруун сэцэн ванг Модун шийтгэж дайнд явуулжээ. Баруун сэцэн ван Баруун хязгаарын хориод аймаг, улсыг довтлон хурааж улс гүрэндээ нэгтгэсэн юм. Хань улсын хаанд энэ тухай м.э.ө. 176 онд мэдэгдэж захидал бичихдээ Модун эзэлж авсан хэд хэдэн аймаг, улсын нэрийг дурдсан билээ. Тэдний нэг Хуцзе (呼揭, Хуге) аймгийг Уйгур гэж 1921 онд Де Грот оноосон байдаг. Г.Немет 1930 онд Хуцзе буюу Уцзе (烏揭, Уйе) бол Огур юм, Огур нь Огузын эртний хувилбар гэсэн санал гаргажээ. Мөн адил саналыг Э.Пуллиблэнк 1983 онд дэвшүүлж Хуцзе/Уцзе (呼揭, EMC. x□-g□at; □□, EMC. □□-g□at < *hagaf) бол Огур/Огуз (Oyug/Oyuz)-ын эртний хэлбэр гэж үзжээ.²

М.э.ө. 177 оноос хойш Хуцзе гэсэн нэр Хүннүгийн түүхэнд дахиж хоёр ч удаа, м.э.ө. 50-иад онд Хуцзе, м.э.ө. 48 оны үед Уцзе гэсэн хэлбэрээр түүхэнд гардаг.

М.э.ө. 58 оны хавар-зун болон өвөл тус тус шаньюй болсон Гихэушянь, Босюйтан хоёр мөн оны төгсгөлөөр харилцан байлдахад Хуханье ялагдаж зүүн зүг зугтжээ. Дараа жилийн (м.э.ө. 57) намар нь баруун гарын Хуцзе (呼揭) ван, Вэйли данху нар үгсэж Босюйтаныг шаньюй суухад гол нөлөөтэй оролцсон баруун гарын сэцэн ванг даруй өөрөө хаан суух далд хүсэлтэй хэмээн худал мэдүүлж хов хүргэв. Босюйтан цэрэглэж баруун сэцэн ванг хүүтэй нь цуг хороожээ. Сүүлд хууртсанаа мэдээд уурлаж данху Вэйлиг алав. Вэйлитэй хамт үгссэн Хуцзе ван үүнийг далимдуулж бослого дэгдээж өөрийгөө Хуцзе шаньюй хэмээн зарлажээ. Хуцзе ванг шаньюй болсныг сонссон баруун югянь ван болон Уциа дувэй нар

¹ *БНМАУ-ын түүх*. Тэргүүн боть. Улаанбаатар: 1966, 79, 134

² De Groot, J.J.M. *Die Hunnen der Vorchristlichen Zeit*. В-Л., 1921, 76, 79; Hamilton J. "Toquz-oyuz et On-uyur", *JA*. Tome CCL. Fasc. n° 1. 1962, 32; Pulleyblank, E.G. "The Chinese and Their Neighbors in Prehistoric and Early Historic Times". - *The Origins of Chinese Civilizations*. Ed. David Keightley. UCP., 1983, 456

өөрсдийгөө Гули (車犁, Чэли), Уциа (烏藉, Уцзи) шаньюй гэж тус тус өргөмжлөв. Хүннү улс хоромхон зуур 5 шаньюйтай болов.¹

Эдгээр Гихэушянь (Хуханье), Босюйтан (Туци), Хуцзе ван (Хуцзе), Баруун югянь ван (Гули/Чэли), Уциа дувэй (Уциа) гэсэн 5 шаньюйгаас Хуцзе ван (шаньюй) бидний анхаарлыг татаж байгаа юм.

Хүннүгийн эзний суудалд ямар хүн суух ёстой нь ойлгомжтой. Дор хаяж Модуны удам, салаа мөчирт багтах язгууртан байх ёстой. Гихэушянь, Босюйтан хоёр бол Модуны 7-р үеийн ач нар ба өөр хоорондоо үенцэрүүд болох бол Гули (Чэли) шаньюй Гихэушяний элэнц өвөг Цетихоу (Цзюйдихоу, м.э.ө. 101-96) шаньюйн ач билээ. Тэдний дунд үндсэндээ хоорондоо холдож, сунжирч буй Модуны ургийн гурван салааны дунд Хүннүгийн хаан ширээний төлөөх тэмцэл өрнөж эхэлснийг далимдуулж баруун гарын Хуцзе ван, Уциа дувэй нар бас шаньюй болжээ. Сурвалжид Хуцзе, Уциа хоёрыг Модун шаньюйн удам гэж тэмдэглэсэн зүйл байхгүй ч тэр хоёр эсвэл тэдний дээд өвгүүд Хүннүгийн “алтан урагтай” худ ургийн холбоотой байсан байх. Эс тэгвээс хүннүгийн орон нутгийн бусад язгууртнууд тэднийг шаньюй гэж үл хүлээн зөвшөөрөх байсан биз.

Тиймээс *хуцзе* аймгийн эзэн бол хүннүгийн шаньюйн охины хүү буюу зээ, *хуцзе* аймаг бол *уйгур* юм гэсэн Н.Я.Бичурин, Де Грот нарын саналыг түүхэн үндэслэлтэй гэж үзэхийн хамт “Вэй улсын судар”-г өгүүлсэн түүх, домгийн агуулгатай үл зөрчилдөж байгааг цохон тэмдэглэе.

Тус аймгийн нэрийг тэмдэглэсэн утга үсгийн эрт (OC), дундад эртний (MC) үеийн дуудлагыг сэргээн тэнхрүүлсэн судалгаа ч хоёр эрдэмтний санал зөв болохыг харуулдаг.

Хуцзе/Уцзе (呼揭/烏揭) гэсэн үгийн 400-аад оны үеийн дуудлагыг ONWC. *ho-gat, *□o-gat гэж В.С.Коблин; Хожуу Ханьгийн үеийн дуудлагыг LH. *ha-g□at, *□a-g□at гэж А.Шуесслер; Түрүү Ханьгийн үеийн дуудлагыг ЗХ. *□ā-kat, *□ā-kat гэж С.Старостин нар тэнхрүүлсэн нь Хуцзе/Уцзе гэсэн үгийн язгуур хэлбэр Уйгур, Огур, Огуз юм гэж оноосон Де Грот, Г.Немет, Э.Пуллиблэнк нарын санал зөв болохыг давхар нотолж байгаа юм.

Тэгэхээр *уйгуруудын* өвөг дээдэс Модуны үеэс Хүннү гүрэнд захирагдаж, баруун гарт нь нутаглан сууж түүхэнд Хуцзе/Уцзе нэрээр тэмдэглэгдэж байжээ гэж үзэх бүрэн боломжтой боллоо.

Тус аймгийн газар нутгийг ч тогтоох боломж бий. Хуханье-гийн ах Хутуусы нь

¹ De Groot, J.J.M. *Die Hunnen der Vorchristlichen Zeit*. В-Л., 1921, 209-211; Таскин, В.В. *Материалы по истории сюнну*. Выпуск 2. Москва: 1973, 33-33

м.э.ө. 56 онд өөрийгөө Чжичжи шаньюй өргөмжлөв. Хоёр жилийн дараа Хуханье, Жуньчэнь шаньюй нарыг дараалан довтолж ялаад Шаньюйн гол ордонг эзэгнэв. Хуханье нүүж Ханьгийн хилийн харалдаа нутагт түр хоргодон суух болов. Тэр цагт түүний сайд түшмэл явсан нэгэн салж нутагтаа баруун гартаа харьжээ. Туци, Жуньчэнь шаньюй нарын дүү болох энэ этгээд нутагтаа ирээд ах нарынхаа захирч асан цэргийн үлдэгдэлийг цуглуулав, өөрийгөө Илимү шаньюй гэж өргөмжлөв. Илимү нь Увэй (м.э.ө. 114-105) шаньюйн удмаас гарсан дөрөвдэх шаньюй болох бол Хуханье, Чжичжи нар харин Увэйн дүү Цетихоугийн удмын шаньюй нар юм. Өмнө зүг нүүсэн Хуханье-г хүч сул гэж үзсэн Чжичжи шаньюй цэргээ авч Илимү-г дайлахаар хөдлөв. Баруун гарыг эзэгнэгч Илимү ч Хутуусы-г устгахаар бас дорно зүгт хөдөлжээ. Хоёр тал тулгарч байлдахад Илимү ялагдаж, алагдав. Илимүг ялсан ч Чжичжи Хүннүгийн хаадын гол ордондоо буцаагүй билээ. Хань улс дүүд нь тусалж байгааг мэдсэн Хутуусы харилгүй байгаа газраасаа улам барууншилж Усуний хөрш нутаг хүртэл нүүжээ. Хүчээ зузаатгаж, холбоотонтой болохоор шийдсэн Чжичжи шаньюй усуний куньми (昆彌)-д элч зарсан ч элчийг нь тэд хороож орхижээ. Чжичжи-г зугтаж яваа хууль бус шаньюй гэж үзсэн *усуньчууд* түүнийг бутцохихоор 8 мянган цэрэг илгээв. Элч нь сураггүй болсонд сэжиг авч цэргээ бэлдсэн Чжичжи *усуньчуудыг* тосч байлдаад бутцохьжээ. Дараа нь суугаа нутгаасаа хойд зүгт орших *уцзе* (烏揭) аймгийг довтолж хураав. Аймгийн эзэн нь Хутуусы шаньюйн эзэрхийллийг хүлээв. Хойно дахин цэрэглэж суугаа газраасаа баруун зүгт орших *гяньгунийг* дайлж оруулав. Дахиад цэрэглэж суусан нутгаасаа умар зүгт байсан *динлин*ийг байлдан дагуулав. Ингэж Чжичжи шаньюй хоромхон хугацаанд *уцзе* (хуцзе), *гяньгунь*, *динлин*ийг өөртөө нэгтгэж чаджээ.¹

Чжичжигийн эзэлсэн аймгуудын нэг болох Уцзе нь дээр өгүүлсэн Хуцзе билээ.

Таван шаньюйн үед холбогдох баримтаар *хуцзе* буюу *уцзе* нар Хүннүгийн баруунгарт нутагтай Туци шаньюйн өргөөнөөс баруун, баруун хойд зүгт нутаглаж байжээ. Үүнээс гадна Гяньгуний нутаг шаньюйн ордонгоос баруун зүгт 7 мянган ли (2800-2900 км), Чэши (Гусу)-ийн эзэмшлээс умардад 5 мянган ли (2000 км) зайтай оршино, энд Чжичжи шаньюй өргөөлөх болсон гэсэн дам мэдээ бас бий.² Эдгээрээс үзвэл Чжичжи м.э.ө. 49-48 оноос хойш Дорнод Туркестаны Имил (Эмил) эсвэл Ховогийн голоор нутаглах болжээ. Гяньгунь аймгийн нутаг гэж сурвалжид маш тодорхой заажээ. Үүнийг *динлин*, *хуцзе* нарыг эзэлсэн Чжичжи шаньюйн довтолгооны зүг чигийг заасан мэдээтэй нэгтгэж үзвэл тэд Алтайн

¹ Таскин, В.В. *Материалы по истории сюнну*. Выпуск 2. Москва: 1973, 36-37

² Таскин, В.В. *Материалы по истории сюнну*. Выпуск 2. Москва: 1973, 32-33, 37

нурууны хоёр этгээд Эрчис, Ховд зэрэг голуудын саваар нутаглаж байжээ гэж таамаглаж болохоор байгаа юм.

Хуцзе (Уйгур) аймгийн газар нутгийг Де Грот 1921 онд Ховд, Тарвагатай, Семиплатинск хавьд, Динлинийг түүнээс хойш Эрчисийн дунд биеэр байсан гэж үзсэн бол Л.А.Боровкова *уцзе, гяньгунь, динлинийг* Усуний хойд хил Борхорын нурууны умардад Зостын элсний баруун талд гэж 1989 онд, 2001 онд нэмж Монголын Их нууруудын хотгороор нутаглаж байсан гэж үзжээ.¹

Эдгээр нь түүхэн үнэнд нэлээд дөхсөн санал болохыг Туул голын Заамарын шороон бумбагараас олдсон бичгийн дурсгал давхар гэрчилнэ. Түүнчлэн “Пугу фу-гийн эзний бунхны бичээс”-ийн “гүнгийн нэр нь Итушое (乙突朔野), Алтан (Алтай) уулын хүмүүн”² гэсэн мөрүүд *динлин* (өндөр тэрэгтэн), *хуцзе* (уйгур) аймаг хожим Зүүнгар, Алтайгаас нүүж Монгол орны төв Хангайн нуруу, Орхон, Сэлэнгэ, Туулын сав газарт шилжин ирж суурьшсныг шууд нотолж байгаа юм.

Эртний хятад сурвалжийн мэдээг судлаад Дин Цянь (1843-1919) Ховог сайр нутгийн Ховог гол гэж оноосон Пугучжэнь^{3****} голоор Пугу аймаг нутаглаж байгаад сүүлд Туул голын сав газар нутагласан гэж үзсэн⁴ нь агуулгын хувьд, *пугучууд* багтах *өндөртэрэгтнүүд* Алтай, Зүүнгар нутгаас Монгол орны төвийн бүс нутагт нүүж ирснийг шууд гэрчилж байгаа Заамарын олдворын мэдээтэй бараг таарч байна хэмээн үзэж болох юм.

Харин ийм нүүдэл хэзээ болж өнгөрснийг тогтооход туслах баримт хоёр ч сурвалжид үлдсэнийг бид дээр дурдсан юм. Тухайлбал, Ата-Малик Жувейнийн “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” зохиолын домог дахь “*тэдний тоо олиширсонд тэд бусад ард түмний жишгээр өөрсдийн дундаас ахлагч сонгон түүнд захирагдав. Тийм байдлаар Буку ханыг хүртэл таван зуун оныг үджээ*” гэсэн, мөн “Юань улсын судар”-ын Барчук тегиний намтарт тэмдэглэсэн домгийн “*Чингис хааны үеийн Барчук тегиний үе хүртэл 970 жил болсон*”⁵ гэсэн 2 мэдээг хэлж байна. Тус мэдээнүүд бидний таамаглаж байгаагаар Монгол улсын Хангайн

¹ De Groot, J.J.M. *Die Hunnen der Vorchristlichen Zeit*. В-Л., 1921, 221; Боровкова, Л.А. *Занад Центральной Азии во II в. до н.э. – VII в. н.э.* Москва: 1989, 61-62; Боровкова, Л.А. *Царства «Западного края» во II-I веках до н.э.* Москва: 2001, 296, 109, рис. 3

² Цэрэндорж, Ц. “Шороон Бумбагарын бунханы нангиад бичээс”. - А.Очир, С.В.Данилов, Л.Эрдэнэболд, Ц.Цэрэндорж. *Эртний нүүдэлчдийн бунхант булины малтлага, судалгаа.* Улаанбаатар: 2013, 99

³ Дин Цяний Ховог гол гэж оноосон Пугучжэнь голыг Н.Я.Бичурин, Э.Шаванн нар Алтайн нурууны өмнөд бэлийн Эрчис, Хар Эрчис гэж үзжээ.

⁴ Малявкин, А.Г. *Танские хроники о государствах Центральной Азии*. НС., 1989, 170

⁵ Boyle, J.A. *The History of the World-Conqueror*. Vol. I. HUP, 1958, 54; 元史。卷一百二十二。第 2999-3000頁

бүсэд *уйгур* тэргүүт *динлин* (өндөр тэрэгтэн) аймгууд ирж нутагласан цаг хугацааг зааж байна. Эхний домгийн Буку хааныг Ж.Маркварт, П.Пеллио, С.Г.Кляшторный нар түүхэн бодит хүн, Уйгурын гуравдахь хаан Бөгү (759-779, Мэуюй, 牟羽) гэж үзсэн. Барчук тегин ч түүхэн бодит хүмүүн. Тэгэхээр хоёр домгийн **500 он, 970 жил** гэсэн мэдээ бодит түүхэн явдлын тусгал болох учиртай. Уйгурын хожуу хаант улсын Бөгү хааны амьдарч байсан үеэс урагш 500 жил гэвэл 259-279 он, 1211 оны үед Чингис хааныг дагаж, Өгөдэйн хаанчлалын эхээр үхсэн¹ Уйгурын идикут Барчук тегиний амьдарч байсан цаг үеэс хасвал 241-260 он болно.

Монгол орны төв хэсэгт 260-280 оны үед *өндөр тэрэгтэн* (динлин) болон *уйгурууд* нүүж ирсэн гэх бидний саналыг батлахуйц үйл явдал тэр үеийн Монгол оронд өрнөжээ. Эн тэргүүнд Умард Хүннү улс 260-280-аад он хүрч байж сая задарч бутарсан тухай өгүүлэх “Лян улсын судар 54, Олон харь, Өрнөд, Умардын олон жун, Жуйжуй улс” бүлгийн мэдээг дурдаж байна. Түүнд “... Вэй, Цзиний үед *хүннүчүүд* хэдэн зуун бу(ло)-д хуваагдсан ...”² гэж буй нь Умард Хүннү улс бүр хожим 265-317 он хүрч байж задарч бутарсныг мэдээлж байгаа юм. Умард Хүннү задарч бутарснаар III зууны II хагаст зарим овог (було/хүрээ), аймгууд Говь цаашлаад Иньшань уул, бэхлэлт хэрмийг давж өмнө зүгт нүүжээ. Тухайлбал, нэгэн *ху* аймгийн толгойлогч Тайахоу 29300 хүнтэй аймгаа, мөн Хүннүгийн *ху* аймгийн ерөнхий захирагч Дадоу, Дэи, Юйжюй нар 11500 хүнтэй хүрээнүүдээ дагуулж 284, 287 онд Цзинь улсыг дагасан бол 286 онд Хүннүгийн харьяат *дудабо*, *вэйша* зэрэг *ху* нар одоогийн Шэньси мужийн төв хэсэгт нүүж очжээ. Түүнчлэн цифугийн*жуфу*, *чулян*, *чилу* овгууд III зууны тавь, жараад онд Говийн арын нутгаас Да Иньшань (Даланхар) ууланд нүүж очжээ.³ Эдгээр олон нүүдэл суудлын уг шалтгаан Лян улсын судрын мэдээлж байгаачлан Умард Хүннү задарсантай шууд холбоотой. Мөн Шэнлэ (盛樂, Өвөрмонгол, Хорингэр) төвтэй *сяньбитабгачийн* Ливэй (173-220-277) хааны сүүлчээр табгачийн тонуул морьт цэргүүд умард зүгт дээрэм тонуул хийдэг байсан, тобагийн Ито гэгч 297 онд элсэн талын ард гарч, өрнөдөд 30 гаруй эзэмшлийг байлдан дагуулсан явдал ч Умард Хүннү бутарсантай холбоотой.

¹ Рашид ад-дин. *Сборник летописей*. Том I, книга 2. Москва: 1952, 152; Том I, книга 1. Москва: 1952, 149

² 梁書. 卷五西。列傳諸夷，西北諸戎，芮芮國。第817頁; Таскин, В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Москва: 1984, 289

³ 晉書. 卷十七。列傳四夷，北狄，匈奴。第2549頁; Таскин, В.С. *Материалы по истории древних кочевых народов группы дунху*. Москва: 1984, 89

Тиймээс одоогийн Монгол оронд төвлөрсөн засаг алга болж Умард Хүннү олон овог, аймагт хуваагдаж бутарсан 260-280 оны үед *динлин* (өндөр тэрэгтэн), *уйгурууд* Монголын төв Хангайн бүс нутагт нүүж ирсэн гэж үзэж байна.

Өөрсдийнх нь аман түүх домгийн мэдээ баримт, Н.Я.Бичурин, Де Грот зэрэг эрдэмтний судалгааг үндэслэн боловсруулж уншигч нартаа толилуулж буй санал маань гадаадын зарим эрдэмтний үзэл, онолоос зөрнө. Жишээлбэл, хятад сурвалжид үлдсэн хүннү үгтэй хамгийн ойр нь хожмын уйгур хэл гэх саналыг Ф.Хирт XX зууны эхээр дэвшүүлсэн бол XXI зууны эхэнд С.Г.Кляшторный Төв Азийн эртний аймгийн холбоодын нэг бол *уйгурууд* юм, тэд хожуу *хүннү* нартай шууд удам гарвалын (генетик) холбоотой гэж дүгнэсэн.¹ Гэтэл *уйгурууд* Хүннү гэхдээ бүр Модун шаньюйн үед түүх сударт тэмдэглэгдсэн, *хүннү* нартай зэрэгцэн оршиж байсан эртний аймаг юм. Тэгээд ч Умард Хүннүгийн хүч суларч, задарч бутрах үед *уйгур* болон *өндөр тэрэгтнүүд* Монголын төв хэсэгт нүүж ирсэн тул *хүннү* нартай угсаа гарвалын хувьд огт холбогдохгүй болно.

Abstract: The historical sources mentioned that ancestors of the Uighur khagans were descendants of the HunnuShanyu's princess. In this article, the author suggested that High Carts who go under the western winger of Hunnu Empire and dwelled in the Altai and Dzungaria region, by 260-280 they migrated from their country to the Central Mongolia and dwelled in Khangai mountainous region. Furthermore, the author reach a conclusion that the Uighurs were not the descendants of the Hunnu's.

¹ Hirth, F. "Sinologische Beiträge zur Geschichte der Türk-Völker", *ИИАН* Т. XIII, №2, 1900, 222; Кляшторный, С.Г. *Рунические памятники Уйгурского каганата и история евразийских степей*. СПб., 2010, 174